

БАТЛАВ.  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д. ГАНМАА

**"ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН СТРАТЕГИЙН ХУДАЛДАН  
АВАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ГҮЙЦЭТГЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ  
БИЙ БОЛСОН АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ЗОРИЛГООР ХОЛБОГДОХ ТОГТООЛ,  
ШИЙДВЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ" ҮҮРЭГ БҮХИЙ  
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно" гэж, Эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Монгол Улсын Их Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 6.1.1.төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох" гэж заасан байна.

Түүнчлэн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Зорилт 2.2-ын 2.2.19-д "Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгана.", 2.2.20-д "Төрийн өмчийн эмнэлгийн санхүүжилтийн болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.", 2.2.36-д "Иргэд орчин үеийн эмчилгээ, оношилгооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ." 2.2.37-д "Иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ." гэжээ.

Гэвч эрүүл мэндийн санхүүжилтийг 2021 оноос хойш шинэчилж ирсэн ч өнөөдөр хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүндрэл учирч иргэдийг хувийн төлбөрөөс үүдсэн санхүүгийн эрсдэлд оруулах, тэгш байдал алдагдах, төрийн эмнэлгүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх зэрэг нөхцөл байдал үүсээд байна. Эдгээр асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.", Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна" гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.-д "Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой

нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор байгуулна”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.-д “Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог байгуулна” гэж тус тус заасныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь энэхүү асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах саналыг гаргаад байна.

## **1.2. Практик хэрэгцээ шаардлага**

Монгол Улсын Засгийн газраас эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, эрүүл мэндийн тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хуваагдмал эх үүсвэрүүдийг нэгтгэх, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих, стратегийн худалдан авалтыг хийх, төрийн эрүүл мэндийн байгууллагуудыг гарц, үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, нэгдсэн эмнэлгүүдийг хагас бие даалгахад чиглэсэн хууль эрх зүйн багц өөрчлөлтийг өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлаас Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ний өдөр нэмэлт, өөрчлөлтийг оруулж, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Санхүүжилтийн шинэчлэлийн хууль, эрх зүйн өөрчлөлтүүдийн хүрээнд улсын төсвөөс улсын эмнэлгүүдэд “эдийн засгийн ангиллаар” хуваарилдаг байсан 496 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сан руу шилжүүлж, төлбөрийн арга, журам, зарчмыг нэг болгож Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь нэг худалдан авагч болж стратегийн худалдан авалтыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжсэнээр хэд хэдэн чухал үр дүнд хүрсэн бөгөөд үүнд: а) эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болох улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрүүдийг нэгтгэсэн; (б) тусламж, үйлчилгээг худалдан авах нэг худалдан авагчийн тогтолцоог бий болгосон; (в) стратегийн худалдан авалтыг эхлүүлсэн. Ийнхүү 2021 оноос эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэгтгэж, тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж тодорхойлсон зорилго нь хүн амд шаардлагатай тусламж, үйлчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндээс нь үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн.

Дээрх шинэчлэлийн үр дүнд 2021 оноос өмнө нэг иргэн жилд 2.0 сая төгрөгт багтах тусламж, үйлчилгээ авах боломжтой байсан бол стратегийн худалдан авалт буюу нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр 2.0 сая төгрөгөөс дээш төгрөгт багтах тусламж, үйлчилгээг 2021 онд 17754 иргэн авсан. 2024 онд 142207 болж 8 дахин нэмэгдсэн байна. Мөн 2020 онд нийт хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо 18.3 сая байсан бол 2024 онд 26.3 сая болж 43.7 хувиар нэмэгджээ.

Хэдийгээр хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн, санхүүгийн хамгаалалт сайжирсан, төрийн эмнэлгүүд гүйцэтгэлээрээ санхүүжих боломж бүрдсэн ч Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл алдагдаж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэвийн санхүүжүүлэх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн.

Иймд эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлсэн стратегийн худалдан авалтын үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах Хянан шалгах түр хороог байгуулж ажиллуулах шаардлага бий болсон байна.

### **Хоёр.Тогтоолын төслийн бүтэц, агуулга**

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үндэслэл, шалгуурын дагуу боловсруулагдсан бөгөөд төсөлд Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг тусгасан.

Түр хороо нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд үйл ажиллагааныхаа тайланг Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахаар тусгасан.

**Гурав.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцэж байгаа болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.